



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/204

Мандалговь

Инженерийн хийцтэй худаг ашиглалтад
хүлээж авах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил" төслийн хүрээнд тус аймгаас хамрагдсан сумдад гаргасан Баянжаргалан суманд 1 (нэг), Гурвансайхан суманд 1 (нэг), Өндөршил суманд (1), Өлзийт суманд (1), Дэлгэрхангай суманд (1) инженерийн хийцтэй худгийг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнхжаргал (ХХААГ-ын дарга)
Нарийн бичгийн дарга: Ж.Батбилэг (ХХААГ-ын МҮА-ны дарга)
Гишүүд:
Б.Цэрэнсугир (БОАЖГ-ын мэргэжилтэн)
Т.Цэвэлмаа (Баянжаргалан сумын Засаг дарга)
Л.Мөнхбадрах (Өндөршил сумын Засаг дарга)
Л.Өлзийбат (Гурвансайхан сумын Засаг дарга)
А.Эрдэнэбат (Өлзийт сумын Засаг дарга)
О.Батчулуун (Дэлгэрхангай сумын Засаг дарга)
М.Сонинбилэгт (Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл)

Хоёр. Хүнс хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайд нарын 2005 оны хамтарсан тушаал болон Монгол Улсын MNS 6088:2010 стандарт "Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага"-ын дагуу хүлээн авч дүгнэлтээ танилцуулахыг ажлын хэсэг (Б.Мөнхжаргал)-т даалгасугай.

Гурав. Ашиглалтад хүлээн авсан инженерийн хийцтэй худгуудыг малчдад хариуцуулж өгөхийг Баянжаргалан сумын Засаг дарга Т.Цэвэлмаа, Өндөршил сумын Засаг дарга Л.Мөнхбадрах, Гурвансайхан сумын Засаг дарга Л.Өлзийбат, Дэлгэрхангай сумын Засаг дарга О.Батчулуун нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010576